



2026 оны хичээлийн жил

Жинжү Эрүүл Мэндийн Сургууль

К- Эрүүл мэндийн тэнхим

Гадаад оюутнуудад зориулсан асрамжийн сувилагч бэлдэх 2
жилийн хөтөлбөр Элсэлтийн удирдамж



진주보건대학교
JINJU HEALTH COLLEGE



Асрамжийн сувилагч бэлдэх
2 жилийн хөтөлбөрт
Гадаад оюутан элсүүлэх
удирдамж

1



Элсэх Дараалал



Элсэлтийн хуваарь

Дэс дараа	Хугацаа	Тайлбар
Элсэх өргөдөл, материалаа өгөх	2025. 9. ~ 2026. 2.	Шуудангаар болон өөрийн биеэр өгч болно. Өгөх гезер : Элсэлтийн алба
Баримт бичгийн шалгалт	2025. 10. ~ 2026. 2.	
Тэнцсэн хүмүүсийг зарлана	2025. 10. ~ 2026. 2.	Хүн тус бүрт мэдэгдэнэ.
Хичээл эхлэх өдөр	2026. 3. 3.(Даваа)	
Элсэлтийн зөвшөөрөл олгоно	• Đối với người cư trú tại Hàn Quốc : Бүртгэлээ дуусгасны дараа Сургалтын алба 3-т очиж зөвшөөрөлөө авна. • Гадаадад оршин суугчид : - Бүртгэл дууссаны дараа зөвшөөрөлийг өргөдөл гаргагчийн хаягаар цахим шуудангаар эсвэл шуудангаар илгээнэ. - Өргөдөл дээр байгаа хаягаар шууданг илгээгдэх тул цахим шуудан, шуудангийн дугаараа үнэн зөв бичнэ үү. • Сүүлд төгссөн сургуулийг нотлох баримт бичгийн эх хувийг ирүүлээгүй эсвэл банкны хуулгаа ирүүлээгүй тохиолдолд элсэлтийн зөвшөөрлийг олгохгүй. - Апостиль, Солонгосын консулын газар эсвэл Солонгосын элчин сайдын яамны консулаар баталгаажуулна.	

Элсэлтийн авах тэнхим ба элсүүлэх тоо

Ангилал	Элсүүлэх нэгж	Хичээл орох арга	Академик	Элсүүлэх тоо	Эрдмийн зэргийн төрөл
Нийгэм хүмүүнлэгийн ухаан	К – эрүүл мэндийн тэнхим	Долоо хоногоор	2 жил	хязгааргүй	Асаргааны баклавр зэрэг

* К – Эрүүл мэндийн тэнхим : асрамжийн сувилагч (улсын мэргэжлийн гэрчилгээ дипломтой) ангид элсэлт авч байна.

Элсэгчдийн анхаарах зүйлс

- а. Өргөдөл гаргах үед өгсөн мэдээлэл нь бодит байдлаас өөр байвал мэдээлэлийг алдаж, орхиж бичсэнээс үүссэн нөхцөл байдалд өргөдөл гаргагч өөрөө хариуцна.
- б. Өргөдөл гаргагч нь өргөдөл гаргахад тавигдах шаардлагыг хангаагүй, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь хуурамч мэдээлэл, хуурамчаар үйлдсэн, хуурамч болон бусад шударга бус үйлдэлтэй нь батлагдсан тохиолдолд бүртгүүлсэний дараа ч элсэлтийг цуцалж болно
- в. Материал хүлээн авсаны дараа өргөдлийн маягтыг өөрчлөх, хүчингүй болгох, элсэлтийн хураамжийн буцаан олгох боломжгүй бөгөөд бүрдүүлсэн бичиг баримтыг буцаан олгохгүй.
- г. Өргөдөл гаргагч нь өргөдөл гаргахдаа тухайн сургуультай холбогдох боломжтой цахим шуудангийн хаяг, утасны дугаарыг үнэн зөв бичих ёстой. Холбоо барих боломжгүй тохиолдолд (и-мэйл, утас гэх мэт) учирсан аливаа хохиролыг өргөдөл гаргагч өөрөө хариуцна
- д. Өргөдлийн оноо болон үнэлгээний агуулгыг задруулахгүй
- е. Хэрэв ирүүлсэн баримт бичигт хуурамч мэдээлэл, хуурамчаар үйлдсэн, өөрчилсөн нь тусдаа баталгаажуулалтын үйл явцын дараа илэрсэн, эсхүл Цагаачлалын албанаас хуурамч гэрчилгээ бүрдүүлсэн, виз олгохоос татгалзсан зэрэг бусад зөрчил илэрвэл өргөдөл гаргагч нь өргөдөл гаргахад тавигдах шаардлагыг хангаагүй бол элсэх эрхийг хасаж, элсэх зөвшөөрөл олгогдсон байсан ч элсэлт цуцлагдана. (Хичээлийн улирал эхэлсний дараа элсэлт цуцлагдсан тохиолдолд сургалтын төлбөрийг бүрэн буцаан олгохгүй байж болно.)
- ё. Цагаачлалын албаны журмын дагуу оршин суух статусаа сунгах, өөрчлөх боломжгүй бөгөөд өргөдөл гаргагч тухайн улсад хууль ёсоор оршин суух боломжгүй бол элсэлтийг цуцалж болно
- ж. Виз олгоогүйгээс сургалтын төлбөрийг буцаан олгосон тохиолдолд шилжүүлгийн болон үйлчилгээний хураамжийг буцаан олгох дүнгээс хасна
- з. Тэтгэлэг (хөнгөлөлтийг оруулаад) тэтгэлэгт хамрагдагч нь хичээлийн дундаас сургуулиас гарах (сайн дураар орхих мэт) тохиолдолд өгөгдсөн тэтгэлэгийг бүрэн болон хэсэгчлэн буцаан олгохыг холбогдох журмын дагуу шаардаж болох тул анхаарна уу
- и. Бүх баримт бичгийг зарчмын хувьд 6 сарын дотор гаргасан эх хувиар нь ирүүлнэ. Гэхдээ виз олгох шаардлага гэх мэт шалтгаанаас хамааран баримт бичгийн хүчинтэй байх хугацаа өөр байж болно.
- й. Гадаад хэл дээр бичигдсэн бүх бичиг баримтыг солонгос хэл дээр нотариатаар баталгаажуулсан орчуулгатай хавсаргана
- к. Гадаадын иргэдийн орох/гарах, оршин суухтай холбоотой анхаарах зүйлс
 - 1) Холбогдох байгууллага нь Солонгост оршин суухаар нэвтрэх, гарахтай холбоотой бичиг баримтыг гаргаж хүссэн тохиолдолд өргөдөл гаргагч буюу түүний асран хамгаалагч нь уг журмыг биелүүлнэ.
 - 2) Элсэхээр төлөвлөж буй гадаад оюутнууд сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, Жинжү эрүүл мэндийн коллежийн ерөнхийлөгчөөс олгосон элсэлтийн стандарт зөвшөөрлийг гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт өгч тохирох виз, мөн оршин суух зөвшөөрөлөө авна.
- л. Хэрэв холбоо барих мэдээлэл өөрчлөгдсөн бол та Жинжү эрүүл мэндийн коллежийн сургалтын 3-р албаны утсаар (055-740-1716) нэн даруй мэдэгдэх ёстой.
- м. Энэхүү журамд заагаагүй асуудлыг сургуулийн элсэлтийн комиссын шийдвэрээр шийдвэрлэнэ

Элсэлтийн шаардлага

Иргэншил шалгуур	Өргөдөл гаргагч болон түүний эцэг эх хоёулаа гадаадын иргэн байх
Боловсролын шалгуур	Гадаадын аль нэг улсад Солонгост бага, дунд боловсролтой тэнцэх хэмжээний сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь дүүргэсэн (эсвэл дуусгахаар хүлээгдэж буй)
Хэлний шалгуур (3 -с нэгийг хангасан байх)	1. ТОPIK-ийн 3 ба түүнээс дээш түвшнийг (2 жилийн хүчинтэй) эзэмшсэн байх 2. Сэжун институтын солонгос хэлний дунд шатны курсын 1 ба түүнээс дээш түвшинтэй байх 3. Нийгмийн боловсролын хөтөлбөрийн 3-с дээш шатыг дүүргэсэн буюу урьдчилсан үнэлгээгээр 61-с дээш оноо авсан. * Өргөдөл гаргах эцсийн хугацаанаас хойш оноо нь хүчинтэй байх ёстой
Оршин суух шаардлага	1. D-2 (оюутны) виз авах эрхээ хасуулаагүй хүмүүс 2. Элсэн байсан ч тэдний оршин суух статус нь семестер эхлэхээс өмнө D-2 (оюутны) виз болж статус өөрчлөгдөөгүй тохиолдолд элсэлтийг цуцална.



Шалгаруулах арга

Нийт оноо	Дүнг тусгасан харьцаа ба оноо
100 оноо	Баримт бичиг 100% (100 оноо)
	Баримт бичиг: Өөрийн танилцуулга 50% (50 оноо) + Сурах төлөвлөгөө 50% (50 оноо)

Үнэлгээний шалгуур

Үнэлгээний шалгуур	оноо	Үнэлэх шалгуур (агуулгын онцлог, боломжит байдал)				
		Маш сайн (50~45)	Сайн (44~40)	Дундаж (39~35)	Хангалтгүй (34~30)	Маш хангалтгүй (29~0)
Өөрийн танилцуулга	50 оноо					
Сурах төлөвлөгөө	50 оноо					

Элсэлтийн хураамж болон сургалтын төлбөр

Элсэлтийн хураамж	Сургалтын төлбөр (2025 оны хичээлийн жилийн жишиг)	Тайлбар
50,000 won	2.6769.000 won (1 семестр)	Оюутны хураамж багтаагүй

* Học phí có thể thay đổi trong năm học 2026, và học bổng sẽ được cấp sau khi nhập học.

Тэтгэлэг (мөнгөний нэгж: KRW)

ангилал	Тэтгэлэгийн хэмжээ	Шалгуур	Тайлбар
Шилдэг нэгдүгээр курсын оюутан	Эхний семестрийн төлбөрийн 30%	· TOPIK түвшин 4 · Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 4-р түвшин · Сэжон институтын дунд шатны 2 ба түүнээс дээш дүүргэсэн	· Хууль зүйн яамны журмын дагуу солонгос хэлний мэдлэгийг нотлох баримтыг өгөх · Элсэх үед 1 удаа олгоно
	Эхний семестрийн төлбөрийн 40%	· TOPIK түвшин 5 · Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 5-р түвшин	
	Эхний семестрийн төлбөрийн 50%	· TOPIK түвшин 6	
ТОPIK тэтгэлэг	Шалгалтын бүх хураамж	ТОPIK-ын 4-6-р түвшний шалгалт өгөх хүмүүс (Жилд нэг удаа)	
RISE тэтгэлэг	Семестрт 1 сая won дотор	· Сурч байгаа оюутнууд	· Được cấp cho đến khi tốt nghiệp

JINJU HEALTH COLLEGE

K-HEALTHCARE DEPARTMENT

Бүрдүүлж өгөх бичиг баримт

* Солонгос хэлнээс бусад гадаад хэл дээрх бүх бичиг баримтыг солонгос хэлрүү орчуулан нотариатаар баталгаажуулан хавсаргана.

ангилал	Бичиг баримт	Агуулга	Анхаарах зүйл
Үндсэн бичиг баримт	- Элсэх өргөдөл - 4 x 5 см цээж зураг 3 ш	- Сургуулийн элсэлтийн өргөдөлийн маягт - сүүлийн 3 сар дотор авхуулсан өнгөт зураг (засвар хийлгээгүй)	1 хувийг өргөдөлд 2 хувийг нь нөөцөнд
	- Өөрийн танилцуулга ба сурах төлөвлөгөө - Хувийн мэдээлэл цуглуулж ашиглах 3 дагч этгээдэд өгөх зөвшөөрөл	Сургуулийн өөрийн маягтан дээр бичнэ.	
Сүүлд төгссөн боловсролын гэрчилгээ (ахлах сургууль)	- Ахлах сургуулийн (төгсөх гэж буй) гэрчилгээ - Апостиль -р баталгаажуулна эсвэл консулаар баталгаажуулна	- Апостиль (сургууль байрладаг улсаас томилогдсон агентлаг) эсвэл Солонгосын консулын баталгаажуулалт (сургууль байрладаг улс дахь консулын газар) - Хэрэв тухайн улс апостилийн гэрээнд нэгдээгүй бол тухайн сургууль байрладаг улс дахь Солонгосын консулын газар эсвэл Солонгос дахь консулын газарт баталгаажуулсан баримт бичгийг ирүүлнэ.	
	- Ахлах сургуулийн дүнгийн жагсаалт - Апостиль -р баталгаажуулна эсвэл консулаар баталгаажуулна		
Эцэг эхийн иргэншлийг нотлох баримт	Гэр бүлийн харилцааг нотолсон гэрчилгээ (Гадаад улсын засгийн газраас олгосон оюутан түүний эцэг эх харилцааг гэрчлэсэн баримт бичиг)	- Өргөдөл гаргагч болон эцэг эхийн талаарх мэдээлэл (эцэг эх, хүүхдийн харилцаа гэх мэт) заавал байх ёстой - Гэр бүл салсан, эцэг эх нь нас барсан тохиолдолд баримтыг нотлох нэмэлт баримт бичгийг бүрдүүлнэ (гэр бүл салсан/ нас барсныг нотлох баримт бичиг/ дахин гэрлэсэн, ганц бие эцэг эх гэх мэт)	
	Эцэг эхийн гадаад паспорт, иргэний үнэмлэхийн хуулбар	Паспортын хугацаа хүчинтэй байх ёстой	Хэрэв таны паспортын дугаар өөрчлөгдсөн бол та хуучин болон шинэ паспортынхаа хуулбарыг өгөх ёстой.
Өөрийн иргэншлийг нотлох баримт	Өргөдөл гаргагчийн гадаад паспорт, иргэний үнэмлэхийн хуулбар	Өргөдөл гаргах үед таны паспортын хүчинтэй хугацаа дор хаяж 9 сар байх ёстой.	
	- Гадаадын иргэний оршин суух картын хуулбар - Зөвхөн Солонгост оршин суудаг гадаадын иргэдэд хамаатай	Зөвхөн Солонгост оршин суугаа гадаадын иргэдэд	
Санхүүтэй холбоотой бичиг баримт	- Гадаад, дотоодын банкны дансны үлдэгдлийн баталгаа - Санхүүгийн батлан даагчийн бичиг баримт - Ажлын газрын тодорхойлолт ААН ийн гэрчилгээ - Гадаадад сурах зардалыг даах амлалт (элсэлтийн өргөдөлд багтсан)	Өргөдөл гаргасан өдрөөс хойш 30 хоногт багтааж бүрдүүлнэ. (Дансны үлдэгдэл 16.000.000 воноос дээш байх ёстой)	
Хэлний мэдлэг нотлох	ТОPIK (ТОPIK) транскрипт онооны жагсаалт	хүчинтэй байх хугацаанд нотлох баримт болно	
Дотуур байранд хэрэгтэй бичиг баримт	Эрүүл мэндийн үзлэгийн хуудас (сүрьеэ, гепатит В)	Сүрьеэгийн шинжилгээний бичиг (сүрьеэгийн эрсдэл өндөртэй орнуудын хувьд)	Зөвхөн дотуур байранд орохыг хүсэгчид бүрдүүлнэ

* Сүрьеэ өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй улс орнууд: Доор жагсаасан орнуудын өргөдөл гаргагч нь нийгмийн эрүүл мэндийн төвөөс бусад шинжилгээний байгууллагад цээжний рентген шинжилгээ хийлгэсний дараа “сүрьеэтэй өвчтөн биш” гэсэн сүрьеэгийн оношилгооны гэрчилгээг ирүүлнэ.

1. Балба	4. Малайз	7. Бангладеш	10. Узбекистан	13. Хятад	16. Тайланд	19. Лаос
2. Зүүн Тимор	5. Монгол улс 6.	8. Вьетнам	11. Энэтхэг	14. Камбож	17. Пакистан	20. Казахстан
3. Орос	Мьянмар	9. Шри Ланка	12. Индонез	15. Киргизстан	18. Филиппин	



Баримт бичгийг бүрдүүлэхдээ анхаарах зүйлс

1. Баримт бичгийг хүлээн авах эцсийн хугацаа дуустал Сургалтын 3-р албанд биечлэн (эсвэл шуудангаар) ирүүлнэ.
2. Бүх бичиг баримтыг сүүлийн 6 сарын дотор гаргасан эх хэлбэрээр нь ирүүлсэн байх ёстой. Гэхдээ баримт бичгийн хүчинтэй байх хугацаа нь виз олгох шаардлага гэх мэтээс хамаарч өөр өөр байж болно.
3. Өргөдлийн маягтанд сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан өнгөт гэрэл зураг (4 × 5см) хавсаргана.
4. Солонгос, англиас өөр гадаад хэл дээрх бичиг баримтыг солонгос, англи хэлрүү орчуулан нотариатаар баталгаажуулан орчуулга хавсаргана.
5. Эрдмийн зэрэг (боловсрол), гадаадын иргэншил, гэр бүлийн харилцаа гэх мэт өргөдөл гаргахад тавигдах шаардлагыг баталгаажуулахын тулд дээрхээс гадна нэмэлт бичиг баримт шаардаж болохыг анхаарна уу. Ийм баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд тэнцэхгүй байж болохыг анхаарна уу.
6. Бүрдүүлсэн бичиг баримт хангалтгүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасагдах ба дангаар нь бүрдүүлсэн баримтад тулгуурлан баримтыг шалгахад хүндрэлтэй байвал нэмэлт бичиг баримт шаардаж болно.
7. Өргөдлийн маягт, бүрдүүлсэн баримт бичиг (орчуулгыг оруулаад)-ын мэдээлэл худал болох нь тогтоогдсон, эсхүл өөр шударга бус аргаар өргөдөл гаргагч элссэн бол элсэлтийг цуцална. Нэгэнт элсээд байсан ч өргөдөл гаргагч шударга бус аргаар элссэн нь тогтоогдвол элсэлтийг цуцална.
8. Бүрдүүлсэн баримт бичигт байгаа нэр өөр өөр байвал тухайн хүн мөн болохыг нотлох баримт бичгийг (холбогдох улсын шүүх, төрийн албан тушаалтан олгосон) бүрдүүлнэ.
9. Гэр бүлийн харилцааны гэрчилгээнд өргөдөл гаргагч болон түүний эцэг эхийн тухай мэдээлэл (эцэг эх, хүүхдийн харилцаа, гэр бүлийн харилцаа гэх мэт) албан ёсны баримт бичигт заавал тусгагдсан байна.
10. Албан ёсны гэрчилгээ болон холбогдох баримт бичгүүдийг тухайн улсаас олгох хугацаа хойшлогдож болзошгүй тул улс бүрээс ирүүлсэн бичиг баримтын олгох хугацааг урьдчилан шалгана уу.
11. Өргөдөл гаргах үед банкны үлдэгдлийн гэрчилгээг харгалзахгүйгээр өргөдөл гаргагч нь оюутны виз олгох стандарт элсэлтийн зөвшөөрөл авахдаа виз олгох шалгуурыг хангасан банкны үлдэгдлийн гэрчилгээний эх хувийг дахин ирүүлж байж элсэлтийн зөвшөөрөл олгогдоно.

* Гэр бүлийн харилцааны баримт бичгийг ирүүлэх тухай тэмдэглэл

- Хятад иргэншил: Доорх ① эсвэл ②-ийн аль нэгийг сонгоод илгээнэ үү
 - ① Нотариатаар гэрчлүүлсэн өрхийн бүртгэл (хэрэв бүхэл бүтэн өрхийн бүртгэлтэй, эцэг эхийн аль нэг нь гэрийн эзэн бол)
 - ② Төрөл садангийн нотариатаар гэрчлүүлсэн баримт + бүхэл бүтэн гэр бүлийн нотариатаар гэрчлүүлсэн өрхийн бүртгэл (гэр бүлийн гишүүн бүр тусдаа өрхийн бүртгэлтэй эсвэл эцэг эх нь гэрийн эзэн биш бол)
- Вьетнам иргэншил: Нотариатаар гэрчлүүлсэн төрсний гэрчилгээ + гэр бүлийн гэр бүлийн бүртгэл
- Бусад улсууд: Гэр бүлийн бүртгэл эсвэл ураг төрлийн гэрчилгээ, төрсний гэрчилгээ (нотариатаар гэрчлүүлэх шаардлагатай)
- Анхаарах зүйл: Хэрэв та эцэг эхийнхээ салалт, нас барсан, дахин гэрлэсэн, өрх толгойлсон эцэг эхийн статусыг нотлох шаардлагатай бол холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх ёстой.
Жишээ нь) Гэр бүл салалтын гэрчилгээ, нас барсны гэрчилгээ, ганц бие эцэг эхийн гэрчилгээ, төрсөн эцэг эх, асран хамгаалагч болохыг баталгаажуулсан баримт бичиг гэх мэт.


2026 оны хичээлийн жилд бүрдүүлж өгөх бичиг баримтууд

Шалгалтын дугаар	Овог нэр
------------------	----------

Ангилал	No	Бүрдүүлэх бичиг баримт (сүүлийн 6 сарын дотор авсан баримт бичгийн эх хувь)	Олгосон өдөр
Үндсэн бичиг баримт	1	· Элсэх өргөдөл (сургуулийн маягт) (Хэрэв онлайнаар бүртгүүлэх бол цээж зураг оруулах шаардлагатай (4 см × 5 см, 3 хувь ирүүлсэн байх ёстой)	
	2	· Өөрийн танилцуулга, сурах төлөвлөгөө (сургуулийн маягт)	
	3	· Хувийн мэдээлэл цуглуулах ашиглах 3 дагч этгээдэд өгөх зөвшөөрөл	
Боловсролын түвшинг нотлох баримт (Ахлах сургууль төгссөн гэрчилгээ шаардлагатай)	4	· Ахлах сургууль (төгсөх гэж буй) төгссөн гэрчилгээ (Апостиль-р баталгаажуулах эсвэл консулын баталгаажуулалт)	
	5	· Ахлах сургуулийн дүнгийн тодорхойлолт (Апостиль-р баталгаажуулах эсвэл консулын баталгаажуулалт)	
Иргэний харьяаллыг нотлох баримт (аав, ээж, оюутан)	6	· Гэр бүлийн харилцааны гэрчилгээ - Гадаадын засгийн газраас олгосон эцэг эх, эцэг эх, оюутны харилцааны гэрчилгээ	
	7	· Гадаадын иргэнийг нотлох-эцэг (гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэх хуулбар) · Гадаадын иргэнийг нотлох - эх (гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэх хуулбар) · Гадаадын иргэнийг нотлох -өөрөө (гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэх хуулбар)	
	8	· Гадаадын иргэний бүртгэлийн картын хуулбар (Солонгос улсад оршин суудаг гадаадын иргэдийн хувьд)	
Хэлний мэдлэгийн баталгаа (3-с 1 байж болно)	9	· TOPIK 3 ба түүнээс дээш түвшний гэрчилгээ · Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 3 ба түүнээс дээш түвшин · Sejong Institute Солонгос хэлний дунд шатны курс 1 ба түүнээс дээш түвшин	
Банкны үлдэгдлийн баталгаа	10	· Банкны үлдэгдлийн баталгаа (16,000,000 вон ба түүнээс дээш үлдэгдэлтэй байх)	
	11	· Санхүүгийн батлан даагчийн ажлын тодорхойлолт эсвэл ААН-ийн гэрчилгээ	

※ Анхаарах зүйл

1. Тэнцсэн оюутан элслэтийн өргөдөл өгөх үед өгсөн банкны үлдэгдлийн баталгааг үл харгалзан оюутаны виз хүсэхэд хэрэгтэй стандарт элсэлтийн зөвшөөрлийг авахын тулд виз олгох шалгуурыг хангасан банкны үлдэгдлийн баталгааны эх хувийг ирүүлэх ёстой.
2. Сургуульд элссэний дараах журам (Сургуулиас олгосон "элсэлтийн стандарт зөвшөөрөл"-ийн дагуу виз олгох/сунгах асуудлыг элсэгч өөрөө хариуцна.)





2

К- Эрүүл мэндийн Тэнхимийн танилцуулга

К- Эрүүл мэндийн Тэнхимийн танилцуулга

К- Эрүүл мэндийн Тэнхимийн танилцуулга

K-Healthcare тэнхимийн асрамжийн сувилагч бэлтгэх хөтөлбөр нь 2 жилийн хугацаатай хөтөлбөр бөгөөд ахмад настан, өвчтөний бие махбодийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд голчлон мэргэшсэн асаргаа тусламж үйлчилгээний мэргэжилтнүүдийг бэлтгэдэг юм. Та энэ хөтөлбөрийг дүүргэснээр асрамжийн сувилагч (care giver)-ийн улсын мэргэжлийн диплом гэрчилгээ мөн K-Beauty салбарт хувийн гурван мэргэшлийн зэргийг нэгэн зэрэг авах боломжтой. Асрамжийн сувилагчийн мэргэшлийн хөтөлбөрт хамрагдаж, ажилд орсны дараа та E7-2 виз (3 жил, сунгах боломжтой) авах болно. Мөн Солонгост 5-аас дээш жил байх тохиолдолд байнгын оршин суух виз (F-5) авах боломжтой.

Асрамжийн сувилагч гэж ямар ажил мэргэжил вэ

Тодорхой хугацааны мэргэжлийн сургалтад хамрагдаж улсын шалгалтат тэнцэж мэргэжлийн эрх, үнэмлэх авсан мэргэжилтэн бөгөөд мартагч өвчин, харвалт зэрэг өвчнөөр бие даан амьдрахад хүндрэлтэй байгаа ахмад настнуудыг асрах, ахмадын асрамжийн газарт ажиллах, гэрт нь мэргэжлийн асаргаа, бие бялдар, ахуйн тусламж үйлчилгээ үзүүлдэг ажил мэргэжил юм.

➤ Мэргэжлийн эрх үнэмлэх

Улсын мэргэжлийн эрхийн үнэмлэх : Асрамжийн сувилагч

* Хувийн мэргэшил : Үс хуйхны зөвлөх (2-р зэрэг), хувийн өнгө будгийн зөвлөх (2-р зэрэг), үсний будгийн зөвлөх 3-р зэрэг

➤ Мэргэжлийн эрх авах журам дараалал

Шалгуур нөхцөл	Мэргэжлийн шалгалтад тэнцэх
D2(Оюутаны виз), D10(ажил горилох виз) - тэй байх 320 цагийн сургалтыг дүүргэх (ажлын байран дээрх хийсэн 80 цагийн дадлага багтана)	Тэмцэх шалгуур : 1. Бичгийн шалгалт (35 асуулт) 2. Практик шалгалт (45 асуулт) Тус бүр 60% ба түүнээс дээш оноо авсан байх
Мэргэжлийн эрх авах	Удаан хугацаагаар оршин суух
Ахмадын асрамжийн газарт ажилд ороход E7-2 виз(3 жилийн оршин суух) олгоно.	Хөдөлмөрийн гэрээг сунгах тохиолдолд оршин суух хугацааг сунгана F-5 виз өгнө

➤ Ажлын цар хүрээ

- Биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг дэмжих: Хоол идэх, угаах, усанд орхоор явахад нь тусалдаг
- Танин мэдэхүйн үйл ажиллагааг дэмжих: Дууны хичээлд туслах, хамт байх
- Сэтгэл хөдлөлийн үйл ажиллагааг дэмжих: Хамтран ярилцагч байж урам зориг өгнө
- Өдөр тутмын амьдралын дэмжлэг: эрүүл ахуй сахих, хоол бэлтгэх, зугаалах, салхинд гарах, алхах дасгал хийх

➤ Ажлын байрнууд

Сувилагын эмнэлэг, асрамжийн газар, гэрийн асрамжийн төв





К Эрүүл мэндийн тэнхимд элсэх шалгуур

Иргэншил	Элсэх ргөдөл гаргагч болон эцэг эх нь гадаадын харьяат байх
Боловсролын түвшин	БНСУ-ын бага, дунд боловсролтой тэнцэх хэмжээний сургалтын хөтөлбөрийг гадаад улсад бүрэн дүүргэсэн (эсвэл дуусгахаар хүлээгдэж буй)
Хэлний түвшин	1. TOPIK 3 ба түүнээс дээш түвшнийг эзэмших (2 жилийн хугацаатай) 2. Сэжон институтын солонгос хэлний дунд шатны 1 ба түүнээс дээш түвшний сургалтыг дүүргэх 3. Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 3 ба түүнээс дээш түвшнийг дүүргэж, урьдчилсан үнэлгээнд 61 ба түүнээс дээш оноо авсан байх * Оноо нь өргөдөл гаргах эцсийн хугацаа хүртэлх хүчинтэй байх ёстой
Оршин суух нөхцөл	1. D-2 (оюутны) виз авах эрхээ хасуулаагүй хүмүүс 2. Элсэн орох зөвшөөрөл авсан ч хичээл эхлэхээс өмнө оршин суух статусаа D-2 (оюутны) виз болгон өөрчлөхгүй бол элсэлтийг цуцална.

Сургалтын төлбөр (2025 оны хичээлийн жилийн жишиг)

1-р семестр	2-р семестр	Нийт
2,679,000 won	2,679,000 won	5,358,000 won

* Mức học phí có thể thay đổi.

Тэтгэлэг (нэгж: KRW)

ангилал	Тэтгэлэгийн хэмжээ	Шалгуур
Шилдэг нэгдүгээр курсын оюутны тэтгэлэг	Эхний семестрийн төлбөрийн 30%	· TOPIK түвшин 4 · Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 4-р түвшин · Сэжон институтын дунд шатны 2 ба түүнээс дээш дүүргэсэн
	Эхний семестрийн төлбөрийн 40%	· TOPIK түвшин 5 · Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн 5-р түвшин
	Эхний семестрийн төлбөрийн 50%	· TOPIK түвшин 6
TOPIK тэтгэлэг	Шалгалтын бүх хураамж	· TOPIK-ын 4-6-р түвшний шалгалт өгөх хүмүүс (Жилд нэг удаа тэтгэлэг олгоно.)
RISE тэтгэлэг	Семестрт 1 сая won дотор	· Сурч байгаа оюутнууд

К- Эрүүл мэндийн Тэнхимийн танилцуулга

Сургуулийн оюутны байр



Оюутны байрны танилцуулга

Тавилга тоног төхөөрөмж	Байрны төлбөр (өглөө, оройн хоолны төлбөр багтсан)
Ор, ширээ, сандал, хувцасны шүүгээ, LAN кабель, ариун цэвэр, шүршүүрийн өрөө, амралтын өрөө, угаалгын өрөө, дэлгүүр, ресторан	Нэг өрөөнд 2 хүн : 1,289,200 вон (16 долоо хоног)
	1 өрөөнд 1 хүн : 1,959,700 вон (16 долоо хоног)



진주보건대학교 학위과정 입학지원서

Application for Admission



지원자 개인 정보 | Personal Information

Овог нэр Name		성별 Sex	☐ 남(Male)	☐ 여(Female)
국적 Citizenship		생년월일 Date of Birth		
출생국 Country of birth		E-mail 주소 E-mail Address		
여권번호 Passport No.		전화번호 Phone No		
신분증번호 Identification NO.		본국 전화번호 Home Phone No		
현재 주소 Current Mailing Address				

교육 | Education Background

구분 Classify	학교명 Name of School	학교주소 School Address	전공 Major	재학기간 Period of Attendance
고등학교 High School				~
한국어교육기관 Korean language				~
대학교 University				~



입학 희망 학기 및 전공 | Study Plan

입학연도 Year	2026	1학기 Spring	
희망전공 Major	K - 헬스케어과	토픽급수 TOPIK	

유학경비를 부담할 개인이나 기관명 | (Indicate the person(including yourself) or organization that will be responsible for your tuition fee and living expenses)

개인 또는 기관명 Name			
관계 relationship			
직업 Occupation			
주소 Address			
전화번호 Phone No.			
Гарын үсэг Signature		연월일 Date	

※ 본인은 상기 지원자의 유학기간 중 일체의 경비부담을 보증합니다.

2025 . . .

지원자 서명 :



Өөрийн танилцуулга ба сурах төлөвлөгөө

Self Introduction & Study Plan

Өөрийн хүмүүжил, гэр бүлийн орчноо тодорхойлж бичнэ үү

Describe yourself and your family.

Элсэх өргөдөл гаргах сэдэл, элссэний дараах сурах төлөвлөгөө, ирээдүйн карьерынхаа төлөвлөгөөг тайлбарлана уу

Describe the motivation for your application, rough study plan, and future plan.



Хэлний мэдлэгийн оноо болон хэлтэй холбоотой боловсролын туршлагаа дэлгэрэнгүй тайлбарлана уу.
Describe your language proficiency scores and language learning experiences.

Сурах төлөвлөгөөгөө тайлбарлаж бичнэ үү.
Describe your study plan in detail.

Хувийн мэдээлэл цуглуулах· ашиглах 3 дагч этгээдэд өгөх зөвшөөрөл

International Students Agreement on the Collection and Usage of Personal Information

Жинжү эрүүл мэндийн сургууль нь нь гадаад оюутнуудын элсэлтийн өргөдлийг хүлээн авч, боловсруулах зорилгоор дараах байдлаар хувийн мэдээллийг цуглуулж, ашиглаж, гуравдагч этгээдэд өгч болоно. Агуулгыг анхааралтай уншиж, зөвшөөрөх эсэхээ шийднэ үү.

Office of International Affairs at Geogje University intends to collect, use, and disclose your personal information to a third-party as stated below for international students' applications and admissions. Please read the articles below carefully, then check either the 'agree' or 'disagree' box and leave your signature.

☐ Хувийн энгийн мэдээллийг цуглуулах, ашиглах талаархи ерөнхий агуулга

Consent to Personal Information Collection and Usage

Цуглуулж· ашиглах мэдээлэл Items of Personal Information For Collection and Use	Цуглуулж·ашиглах зорилго Purpose of Collected	хадгалах· ашиглах хугацаа Duration to Retain and Use
Нэр, харьяалал, төрсөн он, сар, өдөр, хүйс, хаяг, цахим шуудан, гар утасны дугаар, ахлах сургуулийн бүртгэл, гэр бүлийн харилцааны гэрчилгээ, банкны тэнцлийн гэрчилгээ, төгссөн сургуулийн эцсийн дүнгийн хуудас, солонгос хэлний мэдлэгийн гэрчилгээ (зөвхөн эзэмшигчид), ажлын тодорхойлолт (эцэг эх), орлогын гэрчилгээ, цээж зураг, паспортын дугаар, гадаадын иргэний бүртгэлийн дугаар Name, Nationality, Date of Birth, Gender, Address, E-mail, Mobile Phone Number, High School Records, Family Relation Certificate, Bank Balance Certificate, Highest Academic Certificate, Transcript, Proficiency in Korean Certificate(Holders only), Proof of Employment (Parent), Proof of Income, Photo, Passport Number, Foreigner Registration Number	Гадаад оюутны элсэлт ба менежмент Admission and Management of International Students	Харас байнгын Semi-permanent

* Та дээрх хувийн мэдээллээ цуглуулах, ашиглахыг зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй.

You have the right to refuse the collection and usage of your personal information above.

Гэсэн хэдий ч, хэрэв та зөвшөөрөл өгөхөөс татгалзвал тухайн гадаадын иргэдэд элсэх өргөдөл өгөхөөс татгалзаж болзошгүй.

The items above are required for international students' admissions, so disagree will restrict your application.

► Та дээрх хувийн мэдээллийг цуглуулах, ашиглахыг зөвшөөрч байна уу?

Do you agree to the collection and use of personal information as above?

Тийм
Agree

Үгүй
Disagree

☐ Гуравдагч этгээдэд өгөх мэдээллийн агуулга

Consent to Personal Information Disclosure to a Third-Party

Хүлээн авагч Parties Receiving Personal Information	Өгч буй зорилго Purpose of Collected Personal Information	Мэдээлэлүүд Items of Personal Information For Collection and Use	хадгалах· ашиглах хугацаа Duration to Retain and Use Personal Information
Хууль зүйн яам, Даатгалын компани, аялалын компани Ministry of Justice, Insurance Company, Travel Agency	Гадаад оюутны элсэлт менежмент Admission and Management of International Students	Нэр, иргэншил, төрсөн огноо, хүйс, хаяг, гар утасны дугаар, паспортын дугаар, гадаадын иргэний бүртгэлийн дугаар, цахим шуудан, зураг Name, Nationality, Date of Birth, Gender, Address, Mobile Phone Number, Passport Number, Foreigner Registration Number, Email, Photo	харас байнгын Semi-permanent

* Та дээрх гуравдагч этгээдэд хувийн мэдээллээ өгөхөөс татгалзах эрхтэй.

You have the right to refuse consent to the provision of your personal information to a Third-Party above.

Хэрэв та зөвшөөрөхөөс татгалзвал гадаадын их, дээд сургуульд элсэхийг хязгаарлах боломжтой.

The items above are required for international students' admissions, so disagree will restrict your application.

► Та дээрх байдлаар гуравдагч этгээдэд хувийн мэдээллээ өгөхийг зөвшөөрч байна уу?

Do you agree to provide your personal information to Third-Party as above?

Тийм
Agree

Үгүй
Disagree

20 он(YY). сар(MM). өдөр(DD)

Овог нэр (Name):

Гарын үсэг (Applicant's signature):

Жинжү эрүүл мэндийн сургууль




진주보건대학교
JINJU HEALTH COLLEGE

Жинжү эрүүл мэндийн сургууль, таныг гайхалтай хүн болгож өөрчилнө

Жинжү эрүүл мэндийн сургууль нь түүх,
уламжлалд тулгуурлан байгуулагдсан бөгөөд
бусдаас ялгавартай өрсөлдөх чадвартай мэргжилтэн бэлддэг төдийгүй
төгсөгчддөө ажилд орох үүд хаалгыг нээж өгдөг.
Гайхамшигтай сургуульд гайхалтай ирээдүйг бий болгох оюутнуудын
мерөөдөл нь биелэж хязгааргүй өсөж дэвжих боломжийг бий
болгохын тулд бид хичээж байна.

A nighttime photograph of the Jinju Health College. The main building is a large, modern structure with a glass facade and a distinctive white, zig-zag pattern on its right side. It is illuminated from within, and its lights reflect on the glass. In the foreground, there is a well-manicured lawn with a central circular fountain that has several water jets. The courtyard is paved with a pattern of light and dark stones. Trees and shrubs are scattered around the lawn. In the background, the city of Jinju is visible under a clear night sky. The college's name is written in a stylized, outlined font at the bottom of the image.

JINJU HEALTH
COLLEGE



진주보건대학교
JINJU HEALTH COLLEGE



(52655) 경남 진주시 의병로 51
51, Uibyeong-ro, Jinju City, Gyeongsangnamdo Province,
Republic of Korea. 52655